



У Л А А Н Б А А Т А Р
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

Т О Г Т О О Л

1984 оны 10 дугаар
сарын 01 ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар
хот

Сургууль, цэцэрлэг шинээр нээж
ажиллуулах тухай

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. 1984-1985 оны хичээлийн жилд Октябрийн районы IY хороололд шинээр ашиглалтанд орж байгаа тус бүр 280 ортой цэцэрлэг яслийн дөрвөн комбинатыг 94, 95, 96, 97, Ажилчны районы ОСГ-ны II дүгээр хороонд ашиглалтанд орж байгаа 140 ортой цэцэрлэг-яслийн комбинатыг 73, Найрамдлын районы ОСГ-ны 9 дүгээр хороонд ашиглалтанд орж байгаа 90 ортой цэцэрлэг яслийн комбинатыг 3, Октябрийн районы 4 дүгээр хороололд ашиглалтанд орж байгаа 964 суудалтай сургуулийг 78, мөн районы ОСГ-ны 10 дугаар хороонд ашиглалтанд орж байгаа 640 суудалтай сургуулийг 79 дугаар өгч, 94 дүгээр цэцэрлэг яслийн комбинатыг 1984 оны I дүгээр сарын 25-наас, 95 дугаар цэцэрлэг яслийн комбинатыг 3 дугаар сарын 30-наас, 96 дугаар цэцэрлэг яслийн комбинатыг 6 дугаар сарын 25-наас, 97 дугаар цэцэрлэг яслийн комбинатыг 10 дугаар сарын I-нээс, 73 дугаар цэцэрлэг яслийн комбинатыг 9 дүгээр сарын 15-наас, 7 дугаар цэцэрлэг яслийн комбинатыг 9 дүгээр сарын 16-наас, 78, 79 дүгээр сургуулийг 1984 оны 8 дугаар сарын 25-наас 8 жилийн сургуулиар тус тус нээж ажиллуулахыг Ардын боловсролын хэлтэс /н.Батмагнай/-т даалгасугай.

2. Шинээр ашиглалтанд орж байгаа сургууль, цэцэрлэг яслийн комбинатын орон тоо, төсвийг зохих нормативийн дагуу баталж, санхүүжүүлэхийг Төлөвлөгөөний комисс /н.Ганбаатар/, Санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/-т даалгасугай.

3. 1984 оны 10 дугаар сарын 15-ны дотор 3, 73, 94, 95, 96, 97 дугаар

цэцэрлэг яслийн комбинат, 78,79 дүгээр сургуулийн тамга, тэмдэгийг зохих журмын дагуу хийлгэхийг Ардын боловсролын хэлтэс /н.Батмагнай/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
 ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
 ДАРГА *[Signature]* МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
 ЗАХИРГААНЫ ХАРИУЦАГАТАЙ НАРИЙН
 БИЧГИЙН ДАРГА *[Signature]* Ч.ЖАМБАЛ



[Signature]

[Signature]